

Цөмийн физикийн судалгааны төвийн 60 жилд: Цөмийн хэрэглээний судалгаа болон үйлдвэрлэлд нэвтэрсэн ажлуудаас

Д.Болортуяа*, П.Зузаан

*Монгол Улсын Их Сургууль, Цөмийн физикийн судалгааны төв,
Улаанбаатар 13330, Энхтайван өргөн чөлөө 122/1*

**Э-шуудан: bolortuya_d9@num.edu.mn*

Цөмийн физикийн судалгааны төв нь 1965 онд МУИС-ийн Цөмийн шинжилгээний групп нэртэйгээр анх байгуулагдсан цагаас хойш цөмийн физикийн суурь болон хэрэглээний судалгаа, цөмийн арга, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлуудыг идэвхтэй хэрэгжүүлж иржээ. Энэ хугацаанд цөмийн физикийн хэрэглээ, арга технологийн чиглэлээр эрдэм шинжилгээний 400 гаруй өгүүллэг, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн ажил 8, патент 3, зохиогчийн гэрчилгээ 13, ашигтай загварын гэрчилгээ 2, Монгол Улсын стандарт 20 боловсруулж батлуулсан байна. Нэгэн жарны хугацаанд хэрэгжүүлсэн эдгээр ажлуудыг тоймлож энэхүү өгүүлэлд товч дурдахыг зорилоо.

Түлхүүр үгс: Цөмийн физикийн судалгааны төв, цөмийн шинжилгээ лаборатори, цөмийн, ЦФСТ

PACS number: 01.10.Hx & 01.30.Rr

ОРШИЛ

Цөмийн физикийн судалгааны төв (ЦФСТ) нь 1965 онд МУИС-ийн Цөмийн шинжилгээний групп нэртэйгээр анх байгуулагдсан цагаас цөмийн физик, технологи, инженерчлэлийн чиглэлээр шинэ мэдээлэл, мэдлэг, үр дүн гарган авах, шинэ арга зүй, дэвшилтэт технологи боловсруулах, нэвтрүүлэх эрхэм зорилго тавин үйл ажиллагаа явуулсаар 60 жил болж байна. Үнэхээр ч жаран жил гэдэг эрдэмтэн хүмүүний хувьд ч, эрдэм шинжилгээний байгууллагын тухайд ч түүх өгүүлэх урт хугацаа юм. Монгол тоололд 12 жилийг нэг үе, харин 5 үеийг нэг бүтэн жаран гэж хэмждэг. Нэгэн жарны хугацаанд ЦФСТ-ийн эрдэмтэн судлаачдын зөвхөн цөмийн физикийн хэрэглээний судалгаа, арга технологи боловсруулах, багаж төхөөрөмж бүтээж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн судалгааны ажлуудыг үе үеэр багцлан тоймлож энэхүү өгүүлэлд товч дурдахыг зорилоо.

СУДАЛГАА, ХӨГЖҮҮЛЭЛТ

Эхний үе буюу 1965-1976 онд:

1965-1970 онд профессор Н.Содном, Д.Чүлтэм нарын удирдлага дор МУИС-ийн Цөмийн шинжилгээний лаборатори (ЦШЛ)-ийн багш, судлаачид ЦШНИ-ийн эрдэмтдийн хамт Уолтон-Кокрофтын нейтроны генератор НГ-200-ийг авчран суурилуулж, хэмжилтийн горимыг тохируулан, цөмийн урвалын суурь

судалгаанаас гадна нейтрон идэвхжилийн шинжилгээний ажлыг Монголд эхлүүлэх суурийг тавьсан байдаг [1-3]. Тус генераторыг ашиглан судалгаа, шинжилгээ явуулахад шаардлагатай сцинтилляцийн детектор бүхий 256 сувагт гамма спектрометрийг Ж.Сэрээтэрийн удирдлагаар Ш.Гэрбиш, Т.Жалдан нар 1966-1968 онд ЦШНИ-д бүтээж ЦШЛ-д авчирч суурилуулжээ [4]. Мөн 1970-1972 онд Л.Тогтохбаяр, П.Зузаан, Г.Хүүхэнхүү, Ж.Ганзориг, И.Чадраабал, Л.Дашзэвэг нар ЦШНИ-д Со-60 изотопын 1332 кэВ шугамд 3.2 кэВ энергийн ялгах чадвартай, хагас дамжуулагч Ge(Li) детектортой 4096 сувагт “Тензор” анализатор бүхий гамма болон бета спектрометруудыг угсарч ажиллуулан, МУИС-д авчирсан байна [5]. Нейтроны НГ-200 генераторыг минут, секунд, болон миллисекунд, микросекундын хугацааны мужид импульсийн горимд ажиллуулах электрон схемийг хийж генераторын ажиллагааг удирдсанаар богино наст цацраг идэвхт изотопууд үүсгэн тэдгээрийн задралын судалгааг явуулж [6-9], үүний зэрэгцээ (n,2n), (n,p) урвал ашигласан нейтрон идэвхжилийн шинжилгээ хийгдэж эхэлсэн байна [10]. Тухайлбал, 1971-1975 онд профессор Н.Содном, Д.Чүлтэм нарын удирдлага дор ЦШЛ-ийн эрдэмтэн судлаачид байгалийн цацраг идэвх тодорхойлох болон идэвхжилийн анализын судалгааг дээрх багаж төхөөрөмжүүд дээр суурилан хэрэгжүүлж, нейтрон идэвхжилийн шинжилгээ, түүний хэрэглээтэй холбоотой олон ажил хэвлүүлсэн байна. Үүнд: Нейтрон идэвхжилийн шинжилгээнд цикл-

активизацийн арга, нийлмэл материалд уран, торий, иод зэрэг элементийг тодорхойлох арга боловсруулсан нь бодисын найрлагын судалгааны шинэ арга болсон байна [11-12]. Динозаврын ясны минералын кристалл бүтэц, уг ясанд уран, торий ховор шорооны элемент хуримтлагдах болон эсийн мембраныг ураны ион нэвчих үзэгдлийг судлан үр дүнг олон улсын сэтгүүлүүдэд хэвлүүлжээ [13-14].

Монгол улс ОУАЭА-т гишүүнээр элссэнээр 1975-1976 онд тус байгууллагын техникийн хамтын ажиллагааны тусламжтайгаар цацраг идэвхт изотопон цэгэн үүсгүүртэй (^{109}Cd , ^{241}Am , ^{55}Fe), хагас дамжуулагч $\text{Si}(\text{Li})$ ба $\text{Ge}(\text{Li})$ детектортой АНУ-ын ОРТЕК фирмийн энергиэр ялгах рентген флуоресценцийн спектрометрийг хүлээн авч ЦШЛ-д суурилуулан, ажиллагаанд оруулжээ. Ингэхдээ Эрхүүгийн ИС-ийн лабораторийн эрхлэгч, доктор А.Г.Ревенкогийн зааварчилгаагаар П.Зузаан, Ш.Гэрбиш, Б.Далхсүрэн, С.Даваа нар тухайн үед багажийг дагалдан ирдэггүй олон эд ангиудыг өөрсдөө хийж рентген-флуоресценцийн спектрометрийг ашиглан шинжилгээ хийх нөхцөлийг жинхэнэ ёсоор бүрдүүлсэн байна. Уг төхөөрөмжийг зохих бэлтгэлийг хангасны үндсэн дээр 1976 онд ашиглалтанд оруулж геологи, уул уурхай, биологи, хөдөө аж ахуй, хүрээлэн буй орчны судалгаанд ашиглаж эхэлсэн байна [15].

ЦФСТ байгуулагдсанаас хойших эхний 12 жилд Монгол Улсад цөмийн физикийн судалгаа, шинжилгээ хөгжих үндэс суурь тавигдсан, олон улсын хамтын ажиллагаа өргөжсөн, хүний нөөц болон материаллаг баазыг бэхжүүлж чадсан хөгжлийн суурь үе байлаа. Энэ үед цөмийн шинжилгээний суурь багаж төхөөрөмжүүдийг бүтээх, суурилуулах, угсрах, ажиллагаанд оруулахаас гадна цөмийн цацрагийн, нейтрон идэвхжилийн болон рентген-флуоресценцийн шинжилгээ хийх үндэс суурь тавигджээ.

Хоёр дахь үе буюу 1977-1988 онд:

Энэ үеийг нейтрон идэвхжилийн шинжилгээг боловсронгуй болгох; рентген-флуоресценцийн арга зүйг боловсруулан уул уурхай, хүрээлэн буй орчны салбарт хэрэглэх; үйлдвэрлэлийн процессыг хянах багаж төхөөрөмж зохион бүтээж практикт нэвтрүүлэх гэж үндсэн 3 хэсэгт хувааж болох юм.

Нейтрон идэвхжилийн шинжилгээнд: 1977 оноос Унгар улсаас NA-4 нейтроны генераторыг авчирч суурилуулан нейтрон идэвхжилийн шинжилгээнд ашиглах эхлэл тавигджээ. Энэхүү нейтроны генераторыг

монголд авчрахаас өмнө Дубнагийн ЦШНИ-д аваачин ажиллагааг зүгшрүүлэх ажлыг Д.Шагжжамба, Н.Ганбаатар, С.Лодойсамба, Ю.Намсрай, Б.Отгоолой нар гүйцэтгэн, дараа нь МУИС-д авчирч суурилуулан ашиглалтад оруулсан байна. Генераторын хамт манай улсын хувьд анхны IBM-8 төрлийн тооцон бодох техник ТРА/и мини-компьютер, 1978 онд ОУАЭА-ийн төслөөр АНУ-ын PDP 11/05 микро-компьютер суурилуулсан нь цөмийн физикийн туршлагыг автоматжуулахад үсрэлт болсон гэж үздэг. Мөн энэ үед нейтроны изотопон үүсгүүр Pu-Be , ^{252}Cf -ийг авснаар нейтроны генератор болон изотопон үүсгүүрүүд бүхий идэвхжилийн шинжилгээний лабораторийг байгуулж, туршилт судалгааны ажил өргөжсөн байна [1-3]. Тэр цагт физикийн туршлагыг автоматжуулахад зориулсан КАМАК систем ихэд тархаж энэ системээр хийсэн цөмийн электроникийн олон багаж төхөөрөмж зохион бүтээж үйлдвэрлэж байсан учир ТРА/и компьютерыг КАМАК системтэй холбох ажлыг амжилттай хийж гүйцэтгэн КАМАК системийн хэмжих багажуудаас мэдээлэл хүлээн авч боловсруулах бололцоотой болсон юм [16]. Эдгээр багаж төхөөрөмжийг түшиглэн ЦШЛ-ийн эрдэмтэн судлаачид нейтрон идэвхжилийн шинжилгээний аргаар хүнсний бүтээгдэхүүн болон геологийн эрдэс түүхий эдийн найрлагыг тодорхойлсон олон судалгаа хийж, холбогдох аргазүйг боловсруулжээ [17-20]. Тухайлбал, зэс, молибденийн баяжмалын үндсэн болон дагалдах элементүүдийг цөмийн идэвхжилийн аргаар судлан зэсийн баяжмалд алт 1-5 г/т, молибденийн баяжмалд рений 550-600 г/т байгааг тогтоосон [21] бол флюритэд фтор (F), хүнсний бүтээгдэхүүнд азот (N) тодорхойлох судалгааг мөн хийж, зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан байна [2].

Рентген-флуоресценцийн шинжилгээнд: 1977 оноос эх орныхоо эрдэс баялаг, түүхий эд, хүрээлэн буй орчны дээжид химийн элементийн агуулгыг тодорхойлох рентген-флуоресценцийн шинжилгээний өвөрмөц олон аргыг боловсруулан амжилттай хэрэглэж иржээ [22-32]. Тухайлбал, П.Зузаан, Н.Содном, Ш.Гэрбиш, Б.Далхсүрэн нарын эрдэмтэд ванадийгаас молибден хүртэлх элементийг нэгэн зэрэг тодорхойлох дотоод стандартын аргын нэгэн шинэ хувилбар [22-23], зэсийн баяжмалд мөнгө тодорхойлох арга [24], геологийн дээжид ниобий, вольфрам, цагаан тугалга тодорхойлох арга [15, 25-28], өнгөт ба холимог металлын орд газрын дээжид үндсэн болон дагалдах элемент тодорхойлох арга [21, 29-31], стандарт-фоны аргын нэгэн хувилбар [32] зэрэг олон арга

боловсруулсан байна. Улмаар 1985 онд энергиэр ялгах рентген-флуоресценцийн шинжилгээнд рентген хоолойг өдөөгч болгон ашигласнаар аргын мэдрэх чадвар сайжирч, тодорхойлох элементийн тоо нэмэгдэж, уг аргыг хүрээлэн байгаа орчны судалгаанд хэрэглэх боломжтой болов. Ингэснээр хөрс, ургамал, агаар, хүнсний бүтээгдэхүүн, геологи, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнд элементийн анализ хийх, зарим хортой, хүнд элементийг тодорхойлох арга зүйн судалгааны ажлууд хийгдсэн байна [33-37]. Тухайлбал, П.Зузаан нар Монгол-Зөвлөлтийн хамтарсан Хөвсгөл, Сэлэнгийн иж бүрэн экспедицийн судалгааны ажилд арваад жил оролцож, Хөвсгөл нуур орчмын хөрс, ургамлын олон мянган дээжид хийсэн шинжилгээний дүн нь тус нуур орчмын геохими ландшафтын карт зохиоход [38-40], мөн Монгол-Оросын хамтарсан “Эрдэнэт” УБҮ-тэй хамтран ажиллаж хайгуулын хүдрийн 500 гаруй дээжид давхардсан тоогоор 4000 орчим элементийн агуулгыг РФШ-ний аргаар тодорхойлсон [2] нь тус уурхайн нөөцийг тогтооход тус тус ашиглагдсан байна. 1980-аад онд Н.Содном, Ш.Гэрбиш нар “Эрдэнэт” УБҮ-ийн зэсийн баяжмалд мөнгө (Ag) 60 г/т байгааг РФШ-ний аргаар тодорхойлон өгч уг баяжмалын гадаад худалдааны үнийг нэмэгдүүлсэн байна [21, 41-42].

Цөмийн шинжилгээний төхөөрөмж зохион бүтээж практикт нэвтрүүлсэн нь: Цөмийн физикийн судалгаа хөгжиж, ОУАЭА-ийн техник тусалцааны төслүүд хэрэгжсэнээр цөмийн технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх бололцоо олгосон байдаг. 1985 оноос хайлуур жоншны хүдэр болон баяжуулах үйлдвэрийн технологийн дамжлагын баяжмал дахь жоншны хэмжээг хурдан тодорхойлох “Флюорит-1” төхөөрөмжийг профессор Д.Чүлтэмийн удирдлагаар Ж.Ганзориг, Д.Баатархүү, Ж.Сэрээтэр, П.Улаанхүү нар зохион бүтээж Бор-Өндөрийн УБҮ-т суурилуулж ажиллуулсан байна [43]. Энэ нь нейтроны Pu-Be изотопон үүсгүүр ашиглан цөмийн үечилсэн идэвхжилийн аргаар жоншны агуулгыг хурдан тодорхойлдог автомат төхөөрөмж юм. 1980-д оны сүүлээр С.Лодойсамба нар электроникийн хэсгийг сайжруулснаас гадна спектрометрийн тогтворжуулагч нэмж суурилуулан “Флюорит-1М” хэмээн нэрлэж ажиллагаанд оруулсан байна. Хожим тус УБҮ-ийн геофизикчид уг төхөөрөмжөөр хийгддэг шинжилгээний дүнг химийн анализтай харьцуулахад абсолют алдаа 1% гардаг “сайн төхөөрөмж” хэмээн үнэлжээ [1]. 1987 онд уг төхөөрөмжийг улам боловсронгуй болгож, автомашин дээр ачсан хайлуур жоншны

хүдрийг шинжлэх нейтрон идэвхжилийн “Флюорит-2” төхөөрөмжийг төвийн эрдэмтэд мөн зохион бүтээж Бор-Өндөрийн УБҮ-т тавьж ажиллуулснаар үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлсэн байна. “Флюорит” төхөөрөмжийг зохион бүтээсэн эрдэмтэд Олон Улсын Оюуны өмчийн байгууллагын “Алтан медаль”-аар 1990 онд шагнуулсан билээ [2, 44].

Гурав дахь үе буюу 1989-2000 онд:

Гурав дахь 12 жил бол Монгол Улсад нийгэм солигдсон шилжилтийн хүнд үе байсан ч ЦШЛ-ийг Засгийн Газрын тогтоолоор Цөмийн физикийн судалгааны төв (ЦФСТ) болгон өргөжүүлж, төвийн ахмад эрдэмтэн багш нар цөмийн физикийн суурь болон хэрэглээний судалгаануудыг идэвхтэй үргэлжлүүлж, туршлагын төхөөрөмжийн бааз суурийг бэхжүүлж чадсан үе юм. ОУАЭА-ийн техникийн тусламжаар атомын шингээлтийн спектрометрийн болон радиохимийн лабораториуд нэмж байгуулснаас гадна цөмийн спектрометрийн аналог-тоон хувиргуур бүхий карттай 8 битийн Apple болон IBM PC компьютеруудыг авч судалгааны ажилд ашиглах болсноор физикийн туршлагыг автоматжуулах дараагийн үе эхэлсэн байна [3].

Рентген-флуоресценцийн арга аргачлалыг өргөжүүлэн хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх судалгаа үргэлжилсээр байв [45-46]. 1989-1990 онд Мушгиа худгийн ховор шорооны хүдрийн судалгааг П.Зузааны удирдлагаар тус лабораторийн хамт олон гүйцэтгэж, 5000 гаруй дээжид элементийн шинжилгээ хийж, үр дүнг хэрэглэгчид шилжүүлсэн байна. Энэ ажлыг гүйцэтгэх явцад ховор шорооны элементийн нийлбэрийг өмнө нь зөвхөн сонгодог химийн аргаар тодорхойлдог байсныг РФШ-ний аргаар тодорхойлж болохыг харуулснаас гадна дээрх ховор шорооны элементүүд хоорондоо шугаман хамааралтайг тогтоон цөөн стандарт загвар хэрэглэх боломжийг олгосон нь практик ач холбогдолтой болсон байна [46]. Рентген-флуоресценцийн шинжилгээний аргын мэдрэх чадварыг сайжруулах, хэрэглэгдэх хүрээг өргөтгөх зорилгоор ОУАЭА-ийн техникийн тусламжаар бүрэн ойлтын рентген шинжилгээний спектрометр хүлээн авч хөрс, ус, агаар, эрүүл мэндийн болон хүнсний бүтээгдэхүүний төрөл бүрийн дээжид хүнд металл, химийн зарим хортой элементүүд тодорхойлох арга зүй боловсруулсан олон судалгааг Ш.Гэрбиш нарын судлаачид амжилттай хэрэгжүүлжээ. Ингэснээр хүрээлэн буй орчны бохирдол болон хүнсний аюулгүй

байдлыг хангахтай холбогдсон судалгаа явуулж практикт нэвтрүүлэх боломж бий болсон байна. Тухайлбал, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг биомониторингийн аргаар судлах, Туул, Сэлэнгэ мөрний сав газрын хүнд металлын судалгаа, хүнсний бүтээгдэхүүнд цацраг идэвхт болон хортой, хүнд элемент тодорхойлох зэрэг судалгаа хийсэн байдаг [47-51]. 1998 оноос уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн технологийн процессыг шуурхай хянадаг рентген-спектрийн лабораторийн шинжилгээний арга зүйг боловсронгуй болгох ажлыг П.Зузааны удирдлагаар Н.Гансүх, С.Даваа, З.Дамдинсүрэн нар гүйцэтгэж, нунтаг ба шингэн дээж шинжлэх зориулалттай СРМ-25 ба АР-31 спектрометрүүд дээр зэс, молибдөн, төмрийн агуулга болон шингэн дээжийн нягт тодорхойлох аргуудыг боловсруулж үйлдвэрлэлийн туршилтад 1999, 2000 онд хүлээлгэн өгсөн нь металл авалтыг сайжруулж, үйлдвэрийн үр ашгийг бодитой нэмэгдүүлсэн байна [52-55].

Цөмийн цацрагийн болон идэвхжилийн шинжилгээний ажлууд, холбогдох аргазүй, багаж төхөөрөмж зохион бүтээх ажлууд ч энэ үед идэвхтэй үргэлжилсэн байна. Б.Отгоолой, Х.Сиражет, Д.Чүлтэм, Ж.Ганзориг нар эрчим багатай нейтроны үүсгүүр ашиглан үечлэн шарж, хэмжих аргаар органик бодис дахь азотын хэмжээг тодорхойлох ажлаар зохиогчийн эрхийн гэрчилгээ авч, улмаар буудайны уураглаг чанарыг азотоор тодорхойлох “Уураг” багажийг зохион бүтээжээ [2, 56-57]. Мөн цөмийн аналитик аргуудаар монгол орны нүүрсний орд газрууд болон байгаль орчны дээжүүдэд элементийн иж бүрэн судалгаа хийхээс гадна Б.Отгоолой, И.Чадраабал, Д.Чүлтэм, Д.Шагжжамба нар газрын гадаргаас эртний амьтдын ясыг танадах цөмийн физикийн арга, Н.Ганбаатар, Ш.Гэрбиш нар уран, торий тодорхойлох гамма спектрометрийн арга, ураны хүдрийн дээжид радий, ураны харьцаа тодорхойлох харьцангуй арга буюу уран-радийн цацраг идэвхийн тэнцвэрийг гамма спектрийн шугамын хүндийн төвийн шилжилтээр тодорхойлох арга боловсруулж геологийн дээжид уран, торийн хэмжээг тодорхойлох ажлуудыг 1990-д онд эрчимтэй хийсэн байдаг [58-61].

Монголын цөмийн физикийн салбарын хувьд онцлон тэмдэглэх үйл явдлын нэг нь цөмийн физикийн суурь болон хэрэглээний судалгаа, сургалт явуулах туршлагын үндсэн төхөөрөмж болох Микротрон МТ-22 электроны цикл хурдасгуурыг ажиллагаанд оруулсан явдал байв. Уг төхөөрөмжийг академич Г.Н.Флеров,

академич Н.Содном нарын дэмжлэгээр Д.Баатархүү, Б.Сэргэлэн нарын судлаач инженерүүд ЦШНИ-ийн мэргэжилтэн А.Г.Белов, П.Г.Бондаренко нартай хамтран угсарч, 1993 онд ЦШНИ-ээс ШУА-ийн Физик-Технологийн хүрээлэнгийн Цөмийн хавсарга судалгааны секторт авчран суурилуулжээ. 1995 оноос микротрон дээр электроныг 14 МэВ хүртэл 1-р горимд хурдасган ажиллуулж эхэлсэн байдаг. 1997 онд Засгийн Газрын шийдвэрээр тухайн үеийн ШУА-ийн Цөмийн хавсарга судалгааны сектор, Эрүүл ахуй халдвар судлалын хяналтын албаны Цацрагийн хяналтын төв лаборатори, МУИС-ийн Цөмийн шинжилгээний лаборатори гурвыг нэгтгэн МУИС-ийн харьяа Цөмийн физикийн судалгааны төвийг байгуулсан [1-2]. Ингээд 1997 онд микротрон МТ-22 дээр электроныг 22 МэВ болтол хурдасган 2-р горимд ажиллуулан хурдасгуурын ажиллагааг жигдрүүлэн тогтворжуулж, шаардлагатай дагалдах төхөөрөмжүүдийг ОУАЭА-ийн шугамаар авч ажиллагаанд оруулснаар электрон, нейтрон, гамма цацрагийн хүчтэй үүсгүүрийг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж эхэлсэн байна. Микротрон МТ-22 хурдасгуурыг ашиглан шинжлэх ухаан, технологийн өндөр түвшинд цөмийн урвалын суурь судалгаанаас гадна нейтрон идэвхжилийн, гамма идэвхжилийн, материалын бүтцийн зэрэг цөмийн хэрэглээний судалгаанууд хийгдэж эхэлжээ [62].

Дөрөв дэх 12 жил буюу 2001-2012 онд:

Энэ үеийн ажлуудыг электроны хурдасгуурыг түшиглэн явуулсан хэрэглээний судалгаа, рентген-флуоресценцийн аргазүй, хүрээлэн буй орчны судалгаа мөн олон улсын хурал гэж онцлон хувааж болох юм.

Микротрон МТ-22-ийн хэрэглээ:

Электроны хурдасгуурыг сайжруулах судалгаануудаас гадна тус микротроныг ашиглан ЦФСТ-ийн эрдэмтэн судлаачид 2000-д оны эхээр цөмийн идэвхжилийн шинжилгээний аргаар хүдрийн доторх алтны хэмжээг тодорхойлох аргазүй боловсруулж, тус аргаар геологи, уул уурхайн орд газрын хүдэр болон хөрсний дээжид алт болон дагалдах бусад элементийн шинжилгээг хийжээ [63-66]. Мөн бусад салбарын судлаачидтай хамтран болорын бүтэц, материалын шинж чанар, модны үртэс, зусах буудайг цацрагаар шарах боломж, уураг, шүдний хатуу эд, мах болон хүнсний бүтээгдэхүүний элементийн найрлагыг тодорхойлох судалгаануудыг хийсэн байна [67-73]. Эдгээр бүх судалгааны электроны

худасгууртай холбогдох техник тохируулгыг төвийн инженер Д.Баатархүү хариуцаж байв. 2009-2010 онд Б.Отгоолой, П.Зузаан нарын баг микротрон дээр гамма-цацраг ба нейтроноор нэгэн зэрэг шарж, элементийн шинжилгээ хийх төхөөрөмжийг нөхдийн хамт зохион бүтээж, судалгааны ажилд хэрэглэсэн нь амжилттай болсон бөгөөд уг бүтээлээр патентын эрх авсан юм [74-76]. Үргэлжлүүлэн Г.Дамдинсүрэн нар фосфорит ба түүний технологийн бүтээгдэхүүнд уран тодорхойлох, нейтрон идэвхжилийн аргаар ховор шорооны элемент тодорхойлох ажлуудыг мөн хийсэн байна [77-78].

Рентген-флуоресценцийн аргагүй.
хэрэглээ: Энэ үед РФШ-ний аргаар хүрээлэн буй орчин, уул уурхай, үйлдвэрлэлийн орчны хүнд, хортой элементийн судалгаа, ховор шорооны элемент болон уран тодорхойлох аргазүйн судалгаанууд хийгдсээр байв [79-88]. Ш.Гэрбиш нарын судлаачид ердийн болон бүрэн ойлтын рентген-флуоресценцийн спектрометрийг ашиглан төрөл бүрийн дээжид элементийн анализ хийх хэд хэдэн аргазүйг боловсруулжээ. Үүнд, зэс молибденийн хүдэр баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүний элементийн найрлагыг тодорхойлох, агаарын бохирдлыг биомонитор ашиглан тодорхойлох, усны чанар, исгэлтийн бүтээгдэхүүн, нөөшилсөн жимс, хүнсний ногоо, шүдний хатуу эд зэрэгт хортой, хүнд элемент тодорхойлох арга зүйг үндэсний стандартаар батлуулж, ашигтай загварын гэрчилгээ авсан байдаг [89-95]. Мөн Д.Болортуяа нар Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнтэй хамтран шүүх шинжилгээнд рентген-флуоресценцийн аргазүйг нэвтрүүлэх хэд хэдэн судалгаа хийжээ. Тухайлбал, буудлагын мөрийг тодорхойлох ажлын хүрээнд буудлагын шагйлтын зай болон тухайн буугаар буудсан давтамжийг тогтоох, гарын мөрийн арчдасаар буудсан эсэхийг шалгах, автомашины будгийн өнгийг элементээр ялган тодорхойлох, алт, мөнгөн эдлэлийн сорьцыг хянах зэрэг ажлууд багтана [96-99].

2003-2007 онд П.Зузаанаар удирдуулсан баг РФШ-ний аргаар нүүрсний элементийн агуулга болон нүүрсний үнслэгийг тодорхойлох, нүүрсний илчлэгийг тооцоолох арга зүй боловсруулан практикт нэвтрүүлэх судалгаа хийсэн байдаг. Үүнд, нүүрсний үнслэгийг хурдан шуурхай тодорхойлох анализаторыг ОУАЭА-ийн техникийн тусламжийн төслөөр Польш улсын мэргэжилтнүүдтэй хамтран С.Лодойсамба нар зохион бүтээж, уг багажаар үнслэг тодорхойлох рентген-флуоресценцийн арга болон олсон үнслэгийн утгыг ашиглан

нүүрсний илчлэг тодорхойлох тооцооны аргазүйг Д.Болортуяа нар боловсруулжээ. Эдгээр аргазүйгээ Монгол улсын үндэсний стандартаар батлуулж, нүүрсний үнслэг тодорхойлох анализаторыг аргазүйн хамт Дулааны 4 дүгээр цахилгаан станцад туршин нэвтрүүлсэн байна. Нүүрсний үнслэг тодорхойлох төхөөрөмж, аргуудыг ОУАЭА-ийн Ази-Номхон далайн бүсийн холбогдох тайлан илтгэлд сайшаан, цаашид хөгжиж буй бусад оронд авч хэрэглэхийг зөвлөмж болгож байсан нь уг судалгааны ажлын түвшинг харуулна [3, 100-106].

2006 оноос ЦФСТ-ийн судалгааны чиглэлд Улаанбаатар хотын тулгамдсан асуудал болох хотын агаарын тоосонцрын бохирдлын судалгаа томоохон байр суурь эзэлнэ. Энэ чиглэлээр С.Лодойсамба, Д.Шагжжамба, Г.Гэрэлмаа нарын баг ОУАЭА-ийн техникийн хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлэн агаарын тоосонцрын дээж соруулах, жигнэх болон түүнд элементийн шинжилгээ хийх рентген-флуоресценцийн спектрометр авч, орчны мониторингийн лаборатори байгуулсан нь төвийн судалгааны чадавхийг нэмэгдүүлэхэд чухал түлхэц болов. Ингэснээр агаарын тоосонцрыг аэродинамик диаметрээр нь ялган PM2.5 ба PM10-2.5 хоёр фракцаар дээжийг цуглуулж, тэдгээрт 20 гаруй элементийн шинжилгээ хийж, тоосонцрын эх үүсвэрийг тогтоох, тэдгээрийн агаарын тоосонцорт эзлэх хувь хэмжээг тодорхойлох, өөрчлөлтийг хянах зэрэг судалгааг хийсэн байна [107-111].

Эрдэм шинжилгээний хурал: Манай төв 2000 оноос улсын болон олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж эхэлжээ. Тухайлбал, Монгол-ЦШНИ-ийн хамтарсан “Цөмийн физикийн хэрэглээний асуудлууд”, “Микротроныг тулгуур болон хавсрага судалгаанд хэрэглэх нь” зэрэг сэдэвтэй олон улсын сургууль семинар хийж байгаад “Орчин үеийн физикийн асуудлууд” нэртэй олон улсын эрдэм шинжилгээний цуврал хурал болж өргөжүүлэн 6 дахь хурлыг зохион байгуулаад байна. Мөн 2004 онд “Уул уурхайн үйлдвэрт технологийн шинэчлэл ба автоматжуулалтын чиглэлээр хийсэн ажлууд (Эрдэнэт УБҮ-ийн жишээн дээр)” хурлыг М-Си-Эс Электроникс ХХК-тай хамтран зохион байгуулсан байдаг. 2006 оноос профессор П.Зузааны санаачилгаар Монгол Улсад рентген шинжилгээний онол, аргазүйг хөгжүүлэх, өргөжүүлэх, салбарын судлаачдыг дэмжих, сүүлийн үеийн дэвшилийг түгээн дэлгэрүүлэх, олон улсын эрдэмтэдтэй харилцан туршлага солилцох зорилгоор “Рентген шинжилгээ” олон улсын хурлыг анх

хийснээс хойш 3 жил тутамд тогтмол зохион байгуулсаар байна [2-3, 112].

Тав дахь үе буюу 2013-2025 онд:

Тав дахь үед цөмийн аналитик аргыг төрөл бүрийн салбарт хэрэглэх судалгаанууд эрчимтэй үргэлжилсээр байна. Тухайлбал, цөмийн аналитик аргаар ховор шорооны элементийн хүдэр, ураны хүдэр, нүүрс, фосфоритын зэрэг уул уурхайн дээжид үндсэн болон дагалдах элемент, Улаанбаатар хот, Туул гол орчим, автомашины батерейн хаягдлын бүс, төмрийн уурхай орчмын хөрс, ус, агаар, ургамал, хүнс, биологийн дээжид цацраг идэвхт болон хортой, хүнд элемент тодорхойлох, хянах судалгаанууд багтана [113-126]. Энэ үед агаарын бохирдлын мониторингийн судалгаа эрчимтэй үргэлжилж, Д.Шагжжамба нар агаар дахь нарийн ба том тоосонцрын агууламжийг цөмийн шүүлтүүр хэрэглэн нэгэн зэрэг тодорхойлох жингийн аргыг үндэсний стандартаар батлуулжээ [127-129]. Мөн Н.Төвжаргал, Л.Энхцэцэг нарын баг агаарын тоосонцрын бүтцийг шинжлэх морфологийн иж бүрэн судалгаа хийж аргачлалыг өргөжүүлсэн байна [130-132].

Цөмийн аналитик аргын судалгаанаас гадна төрөл бүрийн дээжийг цацрагаар шарж, материалын өөрчлөлтийг судлах урьдчилсан судалгаанууд хийгдэж байна. ЦФСТ-ийн микротроноос гарах цацрагийг ашиглан Д.Баатархүү нар байгалийн чулууг цацрагаар шарж өнгөний хувирлыг, Д.Болортуяа нар полимер материалыг шарж өөрчлөлтийг судлах боломжийг судалсан байдаг. Харин өндөр хөгжилтэй орны цацрагийн үүсгүүрийг ашиглан Ц.Амартайван, О.Сүх нарын [133] баг цацрагаар боловсруулсан супер ус шингээгч гарган авах, Н.Отгонпүрэв [134] нар полимержилтын өөрчлөлтийг судлах ажлууд хийж эхний үр дүнг гарган авсан байна. 2021 оноос Б.Мөнхбатаар удирдуулсан баг төмс, лууван зэрэг төрөл бүрийн хүнсний ногоог рентген цацрагаар шарж, хадгалалтын хугацааг уртасгах боломжийг хайсан иж бүрэн судалгааг эрчимтэй хийж байна [135].

Сүүлийн жилүүдэд төвийн хэрэглээний судалгааны хүрээ улам өргөжиж хүний эрүүл мэнд, археологи, соёлын өвийг судлах хамгаалах, цөмийн аналитик аргыг хөгжүүлэхэд дэвшилтэд аргуудыг ашиглах боломжийг эрэлхийлсэн судалгаанууд улам эрчимжиж байна [136-137]. Үүнд, хавдрын эсэд рентген цацрагийн үйлчлэх механизмыг судлах, ПЭТ-СТ зэрэг эмнэлгийн төхөөрөмжийн хамгаалалтын

тооцооллыг орчин үеийн симуляци програмуудыг ашиглан тодорхойлох, археологи, соёлын өвийн дээжийг судлахад цөмийн аналитик аргыг ашиглах зэрэг ажлуудыг дурдаж болох юм. 2022 оноос ОУАЭА-ийн техник хамтын ажиллагааны дэмжлэгээр тус төв орчин үеийн Радиохимийн лабораторийг шинэчлэн байгуулж, холбогдох багаж, төхөөрөмжийг суурилуулан радиохимийн болон материалын судалгааны түвшинг шинэ шатанд гарахаар ажиллаж байна.

ДҮГНЭЛТ

Өнгөрсөн 60 жилийн хугацаанд Цөмийн физикийн судалгааны төв нь Монгол Улсад цөмийн физикийн суурь болон хэрэглээний судалгааг хөгжүүлэх, цөмийн арга, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлуудыг идэвхтэй хэрэгжүүлж иржээ.

Энэ хугацаанд тус төв нь цөмийн физикийн хэрэглээ, арга технологийн чиглэлээр эрдэм шинжилгээний 400 гаруй өгүүлэл, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн ажил 8, патент 3, зохиогчийн гэрчилгээ 13, ашигтай загварын гэрчилгээ 2, Монгол Улсын стандарт 20 гаруйг боловсруулж батлуулсан байна.

Үе үеийн эрдэмтэн судлаачдын хийж бүтээсэн болон одоо хэрэгжүүлж байгаа судалгаануудыг харахад манай төв цаашид хөгжин дэвжих өөдрөг ирээдүй харагдаж байна.

ТАЛАРХАЛ

Цөмийн физикийн судалгааны төвийг өдий зэрэгт хүргэхэд бодит хувь нэмэр оруулсан үе үеийн эрдэмтэн, багш, судлаачид, цөмийн физик, технологи, инженерчлэлээр мэргэшин суралцсан төгсөгчид, манай төвтэй хамтран ажилладаг бүх хүмүүст 60 жилийн ойн баярын мэнд хүргэж, талархал дэвшүүлье.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- [1] П.Зузаан, С.Даваа, Цөмийн физикийн судалгааны төв 40 жилд, МУИС-ийн хэвлэх үйлдвэр (2005).
- [2] С.Даваа, П.Зузаан, Н.Норов, Г.Хүүхэнхүү, Цөмийн физикийн судалгааны төв 50 жилд, Мөнхийн үсэг ХХК (2015).
- [3] С.Даваа, П.Зузаан, “Цөмийн физикийн судалгааны төв 50 жилд”, Sci. tran. NUM, Phys., 438(20), 1–6, (2015).
- [4] Ш.Гэрбиш, Ж.Сэрээтэр, “Электронные схемы для амплитудного и временного отбора импульсов”, МУИС ЭШБ 32, 116-119 (1970).
- [5] Ж.Ганзориг, П.Зузаан, Ж.Сэрээтэр, Ш.Гэрбиш, И.Чадраабал, Г.Үнэнбат, Г.Хүүхэнхүү,

- Л.Тогтохбаяр, "Ge(Li) гамма-спектрометр", МУИС ЭШБ 46, 65-73 (1973).
- [6] Ш.Гэрбиш, Ж.Сэрээтэр, Л.Тогтохбаяр, Д.Чүлтэм, "Установка для исследования миллисекундных изомеров, возбуждаемых быстрыми нейтронами 14 МэВ", МУИС ЭШБ 42, 21-29 (1973).
- [7] Н.Ганбаатар, Ш.Гэрбиш, Л.Дашзэвэг, Ж.Сэрээтэр, С.Лодойсамба, Г.Үнэнбат, Д.Шагжамба, "44 миллисекундный изотоп индий-114, МУИС ЭШБ 2(52), 61-69 (1975).
- [8] Н.Ганбаатар, Ш.Гэрбиш, П.Зузаан, Ж.Сэрээтэр, И.Чадраабал, Г.Үнэнбат, Д.Шагжамба, "Распад индий-112, МУИС ЭШБ 2(52), 71-81 (1975).
- [9] Б.Далхсүрэн, А.Г.Белов, Ш.Гэрбиш, Н.Ганбаатар, "Модуляция дейтронного пучка генератора нейтронов НГ-200", Нейтронная физика IV-М, 254-260 (1977).
- [10] Н.Ганбаатар, Ш.Гэрбиш, Ж.Сэрээтэр, "Определение процентного содержания меди в образцах медных руд методом НАА", ШУА ФТХ-ийн бүтээл 12, 55-59 (1973).
- [11] П.Зузаан, Ж.Сэрээтэр, Г.Хүүхэнхүү, Ш.Гэрбиш, Д.Чүлтэм, "Циклический активационный анализ с перемещением образца", МУИС ЭШБ 43, 71-80 (1973).
- [12] Ш.Гэрбиш, Н.Содном, О.Отгонсүрэн, Ж.Сэрээтэр, Д.Чүлтэм, "Исследование радиоактивности древних костей ядернофизическими методами", МУИС ЭШБ 43, 81-95 (1973).
- [13] Т.Гун-Аажав, О.Отгонсүрэн, Ш.Гэрбиш, Ж.Сэрээтэр, Д.Чүлтэм, "Исследование радиоактивности костей динозавра с помощью гамма спектрометра", Атомная энергия 35 2, 130-132 (1973).
- [14] Ж.Ганзориг, Т.Гун-Аажав, О.Отгонсүрэн, Ж.Сэрээтэр, Ш.Гэрбиш, И.Чадраабал, Д.Чүлтэм, "НАА костей динозавра на уран, торий и РЗЭ", Атомная энергия 35 2, 349-351 (1973).
- [15] Н.Содном, Б.Далхсүрэн, А.Г.Ревенко, Ш.Гэрбиш, П.Зузаан, С.Даваа, "Применение рентгено-флуоресцентного спектрометра с полупроводниковым детектором для определения содержания элементов в рудах", Тезисы докладов первой научной международной конференции "Геология и полезные ископаемые восточной Монголии и сопредельно территории" Уланбаатор, с.11-13 (1977).
- [16] С.Лодойсамба, "Тооцон бодох электрон машинуудын холбоосын КАМАК стандартан универсал байгууламж", Зохиогчийн гэрчилгээ №219, Улаанбаатар (1981).
- [17] Н.Содном, Ш.Гэрбиш, Б.Далхсүрэн, П.Зузаан, Ж.Ганзориг, С.Лодойсамба, Ж.Сэрээтэр, "Цөмийн физикийн арга зүй боловсруулж, практикт хэрэглэж буй судалгааны дүнгээс", МАХН-ын 60 жилийн ойн МУИС-ийн багш нарын ЭШБХ Илтгэлүүдийн товчлол, Улаанбаатар, 8-9 (1982).
- [18] П.Зузаан, Ш.Гэрбиш, Н.Содном, С.Лодойсамба, Ж.Сэрээтэр, "Цөмийн физикийн аргуудыг элементийн анализад хэрэглэсэн нь", МУИС ЭШБ 4(84), 15-31 (1983).
- [19] Б.Далхсүрэн, Ш.Гэрбиш, Ж.Ганзориг, Б.Эрдэв, "Цөмийн идэвхжилийн анализын аргыг улс ардын аж ахуйн зарим салбарт хэрэглэх", ШУА-ийн мэдээ 4, 8-12 (1984).
- [20] Б.Отгоолой нар, "Нейтронно-активационный анализ вольфрамитов и медно-молибденовых концентратов с использованием надтепловых нейтронов", Препринт ОИЯИ, 18-81-819, Дубна (1981).
- [21] Ш.Гэрбиш, "Ядерно-физические методы определения основных и сопутствующих элементов медно-молибденовых руд и концентратов", МУИС ЭШБ Физик 3(132), 301-311 (1997).
- [22] Н.Содном, Б.Далхсүрэн, А.Г.Ревенко, Ш.Гэрбиш, П.Зузаан, С.Даваа, "Рентгенофлуоресцентный экспрессный метод определения содержания многоэлементных руд", В кн: Труды Монголо-Советской Керуленской геологической экспедиции "Вопросы геологии и металлогении восточной Монголии", г.Улан-Батор, с.33-47 (1979).
- [23] В.Я.Выропаев, А.Г.Белов, Н.Содном, Б.Далхсүрэн, Ш.Гэрбиш, П.Зузаан, С.Даваа, "Рентген-флуоресцентное определение малых содержаний элементов от ванадия до молибдена с применением нового варианта эталонирования на спектрометре с полупроводниковым детектором", Препринт ОИВИ 18-2279, Дубна. (1979); Атомная энергия 49 2, 90-94 (1980).
- [24] Ш.Гэрбиш, С.Энхбат, М.Энхтуяа, "Экспрессная методика определения содержания серебра в концентратах меди", МУИС ЭШБ 4(57), 155-158 (1982).
- [25] П.Зузаан, Ш.Гэрбиш, Н.Содном, А.Г.Ревенко, Б.Далхсүрэн, "Определение содержания ниобия в геологических образцах с помощью рентгенофлуоресцентного спектрометра с ППД", МУИС ЭШБ 4(54), 135-141 (1982).
